

ГАРЧИГ

- 1–3 Бодлогын нийтлэл
- 4–5 Зохицуулалтын мэдээ
- 6–7 Байр суурь
- 8–9 Тогтвортой санхүүжилт
- 10 Компанийн засаглал, комплайнс
- 11–12 Финтек ба регтек
- 13–19 Судлаачийн индэр
- 20–21 Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гэж юу вэ?
- 22–23 Олон улсын зах зээлийн мэдээ
- 24 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

ЗУДЫН ЭСРЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ


Монгол Улсад үргэлжилж буй зуд эгзэгтэй түвшинд хүрч, нийт нутгийн 90 гаруй хувь нь өндөр эрсдэлтэй байгааг НҮБ-ын агентлагууд мэдээллээ. Манай улс хоёр дахь жилдээ цаг агаарын эрс тэс хүнд нөхцөл байдалтай нүүр тулж байгаа ба өнгөрсөн өвөл нийт нутгийн 70 орчим хувь зудад өртсөн. Монгол Улсын жилийн дундаж температур сүүлийн 80 жилд 2.46 хэмээр нэмэгдэж уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртөж буй улс орны тоонд оруулж байна. 1940 оноос хойш тохиож буй 4 дэх тунадас ихтэй сар болж өнгөрснийг Цаг уур, орчны шинжилгээний газар мэдээлэв. Мөн судлаачид зудын оргил үе нь 2 дугаар сараас 4 дүгээр сар хүртэл үргэлжилнэ хэмээн үзэж байна

Зураг. 2024 оны 01 дүгээр сарын зудын нөхцөл байдал

70% Монгол улсын зудтай болон зуд дөхсөн газар нутгийн хэмжээ

50% зудтай

20% зуд дөхсөн



Эх сурвалж: Нэгдсэн Үндэсний Байгууллагаас хийсэн зудын судалгаа

2024 оны 1 дүгээр сар нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зудын нөхцөл харьцангуй өндөр байна. 2023 оны 01 дүгээр сард нийт нутгийн 17 хувь нь зудтай байсан бол одоо 70 хувь нь зудтай байна.



**ТАНЫ
САНХҮҮГИЙН
МЭДЛЭГТ**

САЙН ЗАСАГЛАЛ


НҮБХХ-өөс сайн засаглалын шинж байдлыг иргэдийн өргөн оролцоог хангах, эрх зүйт ёсонд үндэслэн шийдвэр гаргах, засгийн газрын үйл ажиллагаа ил тод явагдах, иргэдийн хэрэгцээ, сонирхолд соргог мэдрэмжтэй байх, бүх иргэдэд тэгш шударгаар хандах, төрийн сангийн эх үүсвэрийг үр ашигтай, үр нөлөөтэй зарцуулах, улс төрийн хариуцлагатай байх, хөгжлийн төлөвлөлтөд алсын хараатай хандах явдал хэмээн тодорхойлсон байна.



GOOD GOVERNANCE

UNDP has defined characteristics of good governance as widespread participation by all citizens, decision making by rule of law, transparency in the actions of governance institutions, responsiveness to the needs and desires of citizens, equity in the treatment of citizens, effectiveness and efficiency in the use of public resources, public accountability, and the exercise of strategic vision in planning for development.

Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

САНХҮҮГИЙН ИННОВАЦЫГ ДЭМЖИХ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-ын зорилт 6.4-т “Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна” гэж заасан байдаг. Тус зорилтын хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан ногоон санхүүгийн үндэсний тогтолцоог дэмжин хөгжүүлж, олон улсын санхүүгийн арга хэлбэрийг ашиглан байгальд ээлтэй ногоон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан.

бууруулж, амьдралын чанар, хүний хөгжлийг сайжруулж, чанартай боловсрол, сайн засаглалыг бий болгох замаар ногоон, хүртээмжтэй хөгжилд хүрэхээр зорилт тавьсан. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хадгаламжийн даатгалын корпорацын гүйцэтгэх захирлын хамтарсан тушаалаар “Үндэсний тогтвортой санхүүгийн замын зураг”-ыг баталсан. Энэхүү замын зургийн хүрээнд авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд 2030 он гэхэд ногоон зээлийн хэмжээг



Мөн Монгол Улс “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт”-ын хүрээнд 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 22.7 хувиар

банкны салбарт 10 хувь, банк бус санхүүгийн салбарт 5 хувь хүргэх, цаашлаад Монгол Улсыг бүс нутагтаа тогтвортой санхүүжилтийн мэдлэг, манлайллын төв болгох зорилтыг дэвшүүлсэн.

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт зээлийн 5 багагүй хувийг ногоон зээлд олгох, дэд бүтцийн орчин бий болгох, байгаль орчин, нийгэм засаглалын эрсдэлийн удирдлагын зөвлөмж, загвар, аргачлал боловсруулахад зориулна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны стратеги зорилтын 1.3-т “Санхүүгийн зах зээлд ногоон бүтээгдэхүүн бий болгоход бодлогоор дэмжин ажиллах”-аар тусгагдсаны дагуу ногоон зээлийг бодлогоор дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нэгдсэн бодлогын хүрээнд тодорхой нөхцөл шаардлага хангасан ББСБ-ын итгэлцлээр татан төвлөрүүлэх эх үүсвэрийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сулруулж, бодлогын хүрээнд дэмжлэг үзүүлэх зорилготойгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 794 дүгээр тогтоолоор “Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний зохистой харьцаа тогтоох тухай” тогтоолыг баталсан.

Ингэснээр ББСБ –ын эх үүсвэр татах хувь хэмжээ нь дараах гурван нөхцөл шаардлага хангагдснаар тогтоогдоно.

1. Ногоон зээлийн багц нь Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталсан “Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи”-ийн шаардлагыг хангасан байх;
2. Байгаль орчин, нийгэм, засаглалын тогтолцоо, уур амьсгалын эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн байх;
3. Санхүүгийн тайланд тогтвортой байдал болон уур амьсгалын өөрчлөлтийг стандартын дагуу тайлагнасан байх. СТОУС S1 стандарт буюу тогтвортой байдлын стандартын гол зорилго нь байгууллагын тогтвортой байдалтай уялдаатай, ялангуяа байгууллагын мөнгөн урсгал, санхүүжилт татах боломж, санхүүжилтийн өртөг зэрэгт богино, дунд, урт хугацаанд нөлөөлж болохуйц эрсдэл, боломжуудын талаар мэдээллийг тайлагнахыг шаардана. СТОУС S2 стандарт буюу уур амьсгалын өөрчлөлтийн стандарт нь СТОУС S1-ийн бүтцэд тулгуурласан стандарт бөгөөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор учирч болох биет болон шилжилтийн материаллаг эрсдэл, боломжийг тайлагнахыг шаардана.

Иймд дээрх стандартын дагуу ББСБ-ууд мэдээллээ тайлагнаж эхэлснээр богино, дунд, урт хугацаанд байгууллагын хэтийн төлөвт тогтвортой байдал, уур амьсгалын эрсдэлийн асуудлууд хэрхэн нөлөөлж буй, ямар төрлийн эрсдэл, боломжууд бий болохыг ил тод тайлагнах, тогтвортой байдлын тайлан болон байгууллагын санхүүгийн тайлантай нэгтгэн тайлагнаснаар хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх өндөр ач холбогдолтой юм.


Ногоон зээлийг санхүүжүүлэхэд зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалт хангалтгүй бөгөөд хувийн хэвшил, олон улсын байгууллагуудын оролцоо, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, эх үүсвэрийг бодлогоор дэмжих шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Үүнтэй холбоотойгоор ногоон зээлийн төрлийг өргөжүүлэх, үүнийг дагаад тогтвортой санхүүжилтийн хэрэгжилтэд хяналт, мониторинг, үнэлгээний тогтолцоог бий болгох, ногоон уур амьсгалын санхүүгийн бүтээгдэхүүнүүд, санхүүгийн хэрэгслүүдийг стандартчилах боломжийг судалж нэвтрүүлэх, ногоон таксономитой уялдсан ногоон технологийн мэдээллийн сан үүсгэх зэрэг томоохон ажлуудыг хэрэгжүүлэхээр Санхүүгийн зохицуулах хороо төлөвлөн ажиллаж байна.

Олон улсын байгууллагууд, хөрөнгө оруулагчид, хандивлагч орнууд байгаль орчны асуудалд онцгой анхаарч, ногоон хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгөх болсон энэ цаг үед Монгол Улс санхүүгийн урсгалыг тогтвортой хөгжил рүү чиглүүлэх нь нэн чухал болоод байна.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, КИРГИЗИЙН ҮНДЭСНИЙ БАНКТАЙ САНАМЖ БИЧИГ ҮЗЭГЛЭВ



Санхүүгийн зохицуулах хороо Бүгд Найрамдах Киргиз Улсын Үндэсний банк (Төв Банк)-тай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг өнөөдөр үзэглэлээ. Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газрын ордонд болсон уг ёслолын арга хэмжээнд УИХ-ын дарга Г.Занданшатар, Бүгд Найрамдах Киргиз Улсын Сайд нарын танхимын дарга Акылбек Жапаров болон албаны бусад төлөөгчид оролцсон бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Киргизийн Үндэсний банкны дэд дарга Манас Жакыпов нар санамж бичигт гарын үсэг зурсан юм.


Энэ үеэр Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан “Хил дамнасан санхүүгийн үйл ажиллагаа хурдацтай хөгжиж буй цаг үед хяналт, зохицуулалтын байгууллагуудын нягт хамтын ажиллагаа шаардлагатай бөгөөд энэ үед санамж бичиг байгуулсан нь хоёр улсын санхүүгийн зах зээлийн тогтвортой, бүрэн бүтэн байдлыг хангах, салбарын оролцогч, үйлчлүүлэгчдийн эрхийг хамгаалах, бүс нутгийн санхүүгийн интеграцлалыг харилцан уялдаатай хөгжүүлэхэд өндөр ач холбогдолтой” гэдгийг онцлов. Хамтын ажиллагааны хүрээнд хоёр улсын санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн



нэгжүүд, тэр дундаа финтек компаниудыг бодлогоор дэмжих, хил дамнасан санхүүгийн үйл ажиллагааны мэдээлэл солилцох, газар дээрх санхүүгийн хяналт шалгалт хийхэд харилцан туслалцах, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлд хамтран ажиллах юм.

Энэхүү арга хэмжээний дараа Киргизийн Үндэсний банкны дэд дарга Манас Жакыпов, Санхүүгийн зах зээлийн зохицуулалт, хяналтын байгууллагын дарга Пирназаров Марат Тугольбаевич нар Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын Банкны Холбооны удирдлага болон бусад төлөөлөгчдийг Үндэсний банкны байранд хүлээн авч уулзаж, хоёр улсын банк, санхүүгийн байгууллагуудан хамтын ажиллагааг хөгжүүлэх, санамж бичгийн хүрээнд хамтарч хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар санал солилцсон юм.

СҮНГШИЛ ИХ СУРГУУЛИЙН ПРОФЕССОР И ЧАНГ СҮНД САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ “ХҮНДЭТ ЖУУХ” ГАРДУУЛАВ



Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал Албан журмын даатгагчдын холбооны төлөөллийн хамт БНСУ-ын Даатгалын хөгжлийн институт /Korea Insurance Development Institute/-тэй хамтын ажиллагааг эхлүүлэх мөн даатгалын салбарын хураамж тооцоолол, мэдээллийн санг хөгжүүлэх хүрээнд хэрхэн ажиллаж буй үйл ажиллагаатай танилцахаар энэ өдрүүдэд тус улсад ажиллаж байна.

Тэрбээр өнөөдөр хоёр орны санхүү тэр дундаа даатгалын салбарын хамтын ажиллагааны хөгжилд үнэтэй хувь нэмэр




оруулсан Сүнгшил их сургуулийн профессор И Чанг Сүнд Санхүүгийн зохицуулах хорооны “Хүндэт жуух” гардууллаа. Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал энэ үеэр “Монгол Улсын даатгалын салбар тэр дундаа баталгааны даатгалын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд туршлага, мэдлэгээсээ хуваалцаж, манай орны хувьд чухал ач холбогдол бүхий хэд, хэдэн судалгаа шинжилгээний ажлыг удирдан зохион байгуулсны зэрэгцээ хөгжлийн түүчээ болсон хүний нөөцийг чадархжуулах буюу олон улсын түвшинд мэргэшсэн актуарчдыг нэмэгдүүлэхэд ихээхэн хүчин чармайлт, хөдөлмөр зүтгэл гаргасанд тань Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны нэрийн өмнөөс талархлаа илэрхийлж энэхүү жуух бичгийг гардуулж байна” гэсэн юм.

ЗОХИЦУУЛАЛТАЙ САЛБАРУУДЫН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН ГАРЛАА

анхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ыг шинэчлэн баталснаар нээлттэй хувьцаат компаниудаас гадна даатгагч, итгэлцлэлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд дагаж мөрдөх үүргийг хүлээсэн. Зохицуулалттай нийт гурван салбарын 2022 оны үнэлгээний нэгдсэн тайлангаар кодексийн хэрэгжилт 71.7 хувийн гүйцэтгэлтэй байсан юм. Энэ дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос компани тус бүрт зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг өгч мөн биелэлтийг нь өнгөрсөн 12


ДҮРСЛЭЛ 25. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭДЭХҮҮНИЙ ЭРХ БҮХНИЙ АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТҮРШЛАГА (Килээр):



ДҮРСЛЭЛ 26. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:



ДҮРСЛЭЛ 27. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН НАСЖИЛТ БА ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ:



дугаар сард давтан үнэлсэн. Уг үнэлгээгээр кодексийн хэрэгжилт салбаруудад дунджаар 13.2 хувиар өссөн дүнтэй байна. Зохицуулалттай этгээдийн кодексийн хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлэх, үнэлгээний нэгдсэн тайлан, судалгаа гаргах болон салбарын засаглалын зэрэглэл тогтоох нь компанийн засаглалын чиг хандлага, эрсдэлийг тодорхойлох, салбартаа засаглалаар тэргүүлэгч компаниудыг тодруулах ач холбогдолтой. Мөн кодексийн хэрэгжилтийн үнэлгээ, нэгдсэн судалгааг тогтмол хийснээр үнэлгээний дүнг компанийн засаглалын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, зохицуулалтын орчныг боловсронгуй болгоход ашиглаж байна.

БАЙР СУУРЬ

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ДААТГАЛЫН ХАМГААЛАЛТ, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Санхүүгийн зохицуулах хорооны даатгалын газрын ахлах референт Н.Батцэцэгтэй ярилцлаа

Ипотекийн зээл авч буй иргэдэд даатгуулах шаардлага тавьдаг. Зээлдэгч заавал даатгуулах ёстой юу?

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 446 дугаар тушаалаар “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-ын 22.2-т заасны дагуу ипотекийн зээл авч байгаа иргэн нь хөрөнгийн болон зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалд зээлийн үүргийн гүйцэтгэл дуусах хүртэлх хугацаанд заавал хамрагдсан байхаар зохицуулсан.

Таны хариултаас заавал даатгуулах зохицуулалттай гэж ойлголоо. Ипотекийн даатгалын ач холбогдлыг дэлгэрүүлэн тайлбарлавал?

Хөгжингүй орнуудад орон сууцны урьдчилгаа төлбөр нь бага хэмжээтэй, орлого бага, зээлийн эрсдэл өндөр байх тохиолдолд зээлдэгч заавал даатгуулна. Харин хөгжиж буй орнуудад зээл авсан л бол заавал даатгуулах шаардлага тавьдаг.

Манай улсын хувьд ипотекийн даатгалтай холбогдох нарийвчилсан харилцааг зохицуулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо баталсан “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-д ипотекийн даатгал нь ипотекийн барьцаа хөрөнгийн даатгал болон зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал гэсэн 2 тусдаа даатгалын бүтээгдэхүүнээс бүрдэж байна. Уг журмаар даатгуулагч нар өөрт тохирсон даатгалын эрсдэл болон даатгалын компани сонгох боломжийг бүрдүүлсэн гэж хэлж болно.

Ерөнхийдөө даатгал гэдэг таныг ирээдүйд учирч болзошгүй санхүүгийн хүндрэлээс сэргийлэхэд дэмжлэг үзүүлдэг хамгийн оновчтой хэлбэр гэдгийг ойлгох хэрэгтэй. Энэхүү даатгалын хувьд мөн зээлдэгч нас барах, эсвэл хөдөлмөрийн чадвараа алдсаны улмаас зээлийн төлбөрөө төлж чадахгүй болох тохиолдолд даатгалын компани таны өмнөөс зээлийн төлбөрийг олгоно. Нөгөө талаас барьцаа хөрөнгийн даатгал нь орон сууцанд болзошгүй эрсдэл тохиолдоход өмчлөгчид учирсан санхүүгийн хохирлыг барагдуулдаг. Ийм учраас зээлдэгч нарт даатгал зайлшгүй хэрэгтэй юм.

Ипотекийн даатгалын хамрагдалт өнөөдрийн байдлаар ямар түвшинд байна вэ?

Зээлдэгч зээлийн хугацааны туршид холбогдох даатгалд хамрагдах шаардлагатай талаар өмнө дурдсан. Гэхдээ иргэд анх зээл авахдаа л даатгалын гэрээ хийж, даатгалын хураамж төлж байгаа ч даатгалын сунгалт хийлгэхгүй байх тохиолдол элбэг байна.

Арилжааны банкнууд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсны дагуу даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд ипотекийн даатгалын бүтээгдэхүүний хувьд гол мэргэжлийн оролцогчид байдаг. Нийт ипотекийн зээлийн гэрээгээр 60 гаруй хувь нь даатгалтай байх ч зарим банк нийт зээлийн гэрээний 90 гаруй хувь, зарим 20 орчим хувь нь даатгалтай байгаа нь банкнууд дээр уг даатгалын хамрагдалт харилцан адилгүй байгааг харуулж байна.

Та сая зээл авахдаа даатгуулагч амь нас, эрүүл мэндийн даатгал төлөөд дараа нь сунгахгүй тохиолдол элбэг байдаг гэлээ. Ийм тохиолдолд үүсэх эрсдэлийн талаар тайлбар өгөөч.

Яг тийм. Одоогийн зохицуулалтын хүрээнд амь нас, эрүүл мэндийг ердийн болон урт хугацааны даатгалын компаниудад сонголтоор даатгуулах бөгөөд ердийн даатгагчийн хувьд гэнэтийн ослын улмаас даатгуулагч нас барах болон хөдөлмөрийн чадвар алдалтыг, урт хугацааны даатгагчийн хувьд аливаа шалтгааны улмаас даатгуулагч нас барах болон хөдөлмөрийн чадвар алдалтыг даатгахаар зохицуулсан.

Амьдралын даатгалын хувьд даатгуулагчийн нас, хүйс, эрүүл мэндийн байдал, гэрээний хугацаа, даатгалын хамгаалалт, төлбөрийн нөхцөл зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс хамаарч хураамжийн хэмжээг тогтоодог. Ердийн даатгалын хураамжийг тооцоход даатгуулагчийн нас, хүйс, эрүүл мэнд зэргээс үл хамаарах бөгөөд ерөнхийдөө урт хугацааны даатгалаас хураамж нь бага байдаг. Харин даатгуулагч аль болох залуу насандаа амьдралын даатгалд даатгуулах тохиолдолд ердийн даатгалаас бага хураамж төлж, илүү хамгаалалт авах боломжтой.

Гэтэл зээлдэгч нар зээл авах үедээ зөвхөн шаардлага хангах зорилгоор бага хураамж төлж ердийн даатгалд даатгуулснаар даатгалын хамгаалалт нь багасах, цаашид даатгалын гэрээгээ сунгахгүй байх зэрэг нөхцөлүүдийг бий болгож байна.

Өмнө дурдсанчлан тулгамдаж буй гол асуудал нь зээлдэгчийн амь нас, эрүүл мэнд хохирсон тохиолдолд түүний ар гэрийнхэнд нь даатгалын хамгаалалт үйлчлэхгүйгээс болж өндөр дүнтэй зээл төлөх санхүүгийн дарамт учрах, даатгалын ач холбогдол буурах зэргээс үүдэн даатгалгүй зээлийн хэмжээ нэмэгдэх сөрөг талтай. Тодруулбал, Үндэсний статистикийн хорооноос гаргасан тоон мэдээгээр нас баралтын тэргүүлэх шалтгаануудын 10 орчим хувийг гэнэтийн осол зээлдэг бөгөөд одоогийн байдлаар зээлдэгч нар ердийн даатгалын компанигаар зөвхөн гэнэтийн ослын даатгалын гэрээ байгуулдаг. Үүнээс үзвэл зээлдэгч нас барах, хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдах эрсдэлийн 10 орчим хувь нь даатгагдаж байна гэж ойлгож болно. Гэтэл цаана нь 90 хувийн эрсдэл даатгалгүй байна. Харин зээлдэгч нар амьдралын даатгалд даатгуулсан тохиолдолд аливаа шалтгааны улмаас эрсдэл тохиолдоход нөхөн төлбөр авч болно.

Ипотекийн зээл нь урт хугацааны санхүүгийн бүтээгдэхүүн, үүнийг дагаад даатгалын гэрээ ч мөн урт хугацаатай байх шаардлагатайг олон улсын даатгалын зах зээлийн сайн жишгүүд бидэнд харуулж байна.

Иймд ипотекийн зээлдэгчийн амь насны даатгалын гэрээг даатгалын суурь зарчим, олон улсын жишгийн дагуу урт хугацаат даатгалын хэлбэрт оруулан зээлийн хугацаатай уялдуулж, даатгалын хамгаалалт, үр ашгийг нэмэгдүүлэх нь зүйтэй. Ингэснээр зээлийн хугацааны туршид даатгалтай байх, даатгуулагч нарт тохиолдож болох эрсдэлийн хамгаалалт нэмэгдэх зэрэг эерэг үр дагаврууд гарна. Мөн түүнчлэн манай улсын даатгалын зах зээл дээр амьдралын даатгалын эзлэх хувь хэмжээ өсөх, хөгжихөд түлхэц болох юм.

Ипотекийн зээлдэгч нарт урт хугацааны даатгалд даатгуулах боломж нээлттэй байдаг уу?

Хууль тогтоомжийн хүрээнд одоо ч амьдралын буюу урт хугацаат даатгалаар даатгуулах боломжтой. Гэхдээ зээлдэгч нарт урт хугацааны даатгалаар даатгуулах сонголт, нөхцөл нь хүртээмжтэй байна уу гэвэл үгүй. Энэ нөхцөлийг бүрдүүлэхийн тулд Санхүүгийн зохицуулах хороо, банк, банк-даатгалын зуучлагч, даатгалын компаниудын хамтын ажиллагаа чухал юм. Үүний хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос оролцогч талуудтай уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулан тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхээр бодлого, зохицуулалтын санал боловсруулан ажиллаж байна.

Мөн банк болон даатгалын компаниуд зээлдэгч нар урт хугацааны даатгалыг сонгох, даатгалын гэрээ байгуулах ажиллагааг хөнгөвчлөх, тохиромжтой даатгалын бүтээгдэхүүнийг санал болгохдоо чанартай, түргэн шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэхэд технологийн шийдлийг ашиглах бүрэн боломжтой.

Ярилцсанд баярлалаа, тантай дахин ярилцах саналтай байна.

Баярлалаа, та бидний амьдралд нэн шаардлагатай даатгалын талаар дахин ярилцахад таатай байх болно.


ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

ЗУДЫН ЭСРЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Эхлэл 1–р нүүрт

Монгол Улс 2010 онд зудын гамшигт нэрвэгдсэнээс хойш мөсөн зудын нөхцөл байдал дахин ажиглагдаагүй. Тус жил 10.3 сая толгой мал хорогдсон нь улсын нийт малын 25 хувь, 769 мянган хүн өртсөн нь хүн амын 28 хувь юм. Улаан загалмайн мэдээлснээр 220 мянган малчин өрх гамшигт өртөж, 44 мянган өрх мал сүргээ бүхэлд нь, 164 мянган өрх талаас илүүг нь алджээ.

Зураг. 2024 оны 01 дүгээр сарын зудын төрөл (аймгуудаар)




Эх сурвалж: Нэгдсэн Үндэсний Байгууллагаас хийсэн зудын судалгаа

АНУ–ын Засгийн газар нь АНУ–ын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID)–аар дамжуулан 2010 оноос хойш Монгол Улсад гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөрийг дэмжих зорилгоор 8 сая орчим ам.долларын санхүүжилт олгосон. 2024 онд тус агентлаг нь Монголын улаан загалмайн нийгэмлэгт 200 мянган ам.доллар (ойролцоогоор 680 сая төгрөг) олгосон. Энэхүү санхүүжилтийг яаралтай тусламж хэрэгтэй байгаа малчин өрхүүдэд мөнгөн тусламж, өвс тэжээл, түлш шатахуун хэлбэрээр олгох юм.

Байгалийн гамшгийн хүндрэл, давтамж нэмэгдэж, жилийн хохирлын зардал ойролцоогоор 50–70 тэрбум төгрөг (14–20 сая ам.доллартой тэнцэх) байхаар тооцоо гарсан. Сүүлийн 10 жилийн хугацаанд 6 зуд болсон нь малчдын амьдрал ахуйд хүнд гарз хохирлыг үзүүлсэн төдийгүй улсын хэмжээнд тэжээл хангалтгүйн улмаас тэжээлийн үнэ нэмэгдэж байгаа нь эмзэг байдлыг хэмжээг улам нэмэгдүүлж байна.

Зураг. Хорогдсон малын тоо толгой



Эх сурвалж: Нэгдсэн Үндэсний Байгууллагаас хийсэн зудын судалгаа

НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс “2015 оноос хойш уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл улам дордож, байгаль орчны засаглал муу байгаагаас зудын давтамж болоод хүч нэмэгдэж байна.” хэмээн мэдээлсэн. Дээрх мэдээллүүд нь хөдөө орон нутаг дахь бэлчээрийн малчдын аж ахуйг шинэчлэх, хүмүүнлэгийн туслалцаа үзүүлэх, түүнтэй холбоотой тогтвортой шийдэл яаралтай бөгөөд зайлшгүй хэрэгцээтэй байгааг бидэнд харуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023–2024 онд хэрэгжүүлж буй зудын эсрэг авах арга хэмжээ, төлөвлөгөөний гол зорилтууд нь:

- ◆ Яаралтай тусламж хэрэгтэй байгаа хүмүүсийг мэдэж туслалцаа үзүүлэх;
- ◆ Эмзэг бүлгийн малчин өрхийн амьжиргааг хангах;
- ◆ Хүйс, нас, тусгай хэрэгцээт иргэд, орон гэргүй болон бусад эмзэг байдлын шалгуураар тэдгээр хүмүүсийн шаардлагатай хэрэгцээг хангах, тэднийг хүчирхийллээс хамгаалж, хүмүүнлэгийн тусламжийг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш хүртэх боломжийг олгох.

Зудаас урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээний төлөвлөгөө, түүнд томилогдсон хүмүүнлэгийн тодорхойлсноор 150,500 хүнд яаралтайгаар, 33,400 хүнд тусламж шаардлагатай байгааг мэдээлэв.



Эх сурвалж: Нэгдсэн Үндэсний Байгууллагаас гаргасан Монгол Улсын зудын талаарх тайлан 2024

Зудыг даван гарахад шаардлагатай санхүүжилт нь 21.3 тэрбум төгрөг хэмээн тооцоолсноос одоогоор 5.8 тэрбум төгрөг цуглараад байна. Туслалцааг эмзэг байдлын шалгуураар жагсаан амьжиргааны мөнгө олгох, хоол хүнс эм тариагаар хангах, тэжээл шатахуун тараах, иргэдийг орон байр болон яаралтай туслалцаа хэрэгтэй хүмүүсийг түр орон сууцад цуглуулах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газар 2023 оны зунаас өвөл хүртэлх хугацаанд малын тоо толгойг 87.1 саяас 64.6 сая мал болгон бууруулсан. Малыг бууруулах зорилгоор Засгийн газраас 80.4 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн гадаад зах зээлд гаргасан нь өмнөх оноос тав дахин өсжээ. Мах боловсруулах үйлдвэрүүдэд 100 хүртэл тэрбум төгрөгийн (29 сая ам.доллартой тэнцэх) зээл олгож, арилжааны санхүүжилтээр мах экспортлох, нядалгааны газруудад санхүүжилт олгосон ч малын тоо толгойг бэлчээрийн даацтай тэнцвэржүүлэх нь тулгамдсан асуудал хэвээр байна. Ирэх жилүүдэд зуд тохиолдож болзошгүй эрсдэлийг тооцоолон зудын хор хохирлыг багасгах арга зам нь бэлчээрийн даац болон малын тоо толгойн тэнцвэргүй байдлыг арилгах, малчдад ирээдүйд учирч болзошгүй хор хохирлыг даван туулах чадварыг бий болгох, мал аж ахуйг шат ахиулах зэрэг хөдөө аж ахуйн тогтвортой үйл ажиллагааг хангах бодлого боловсруулах хэрэгцээтэй байгааг энэ төлөвлөгөөндөө дурдсан байна.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН 2024 ОН БОЛОН ЦААШДЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГ ХАНДЛАГА

Компанийн засаглалын хөгжлийн чиг хандлага

Хиймэл оюун ухаан:

Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн үйл ажиллагаанд шинэ технологи нэвтэрч, мэдээллийн тусгай сувгийг хөгжүүлэн аюулгүй байдлыг хангаснаар хамтын ажиллагааг ил тод, оновчтой, үр дүнтэй болгож байна. Хиймэл оюун ухаан нь ТУЗ-ийн гадаад болон дотоод үйл ажиллагаанд хувьсгал хийх магадлал маш өндөр.

Эдгээр өөрчлөлт нь аюулгүй байдлын хувьд урьд өмнө тохиолдож байгаагүй шинэ эрсдэлийг бий болгоод зогсохгүй, бизнесийн үйл ажиллагааны хэв маягийг өөрчлөх боломжтой. Компаниуд хиймэл оюун ухааныг зураг үүсгэх, хэл сурах, GPT-4 (Generative Pre-trained Transformer) загвараар тодорхой даалгаврыг хэрэгжүүлэх, видео бичлэг хийх зэргээр ашиглаж болно. Компанийн ТУЗ болон бусад эрх бүхий албан тушаалтнууд хиймэл оюун ухааныг нэвтрүүлэн ашиглах боломж, гарах эрсдэл, түүнд шаардагдах засаглалын цоо шинэ дадлыг анхааралтай авч үзэх нь чухал.

Ёс суртахуун:

Шинэ технологийг нэвтрүүлснээр зарим ёс зүйтэй холбоотой асуудлууд үүсч болзошгүй. Тухайлбал, хиймэл оюун ухаан нь мэдээлэл цуглуулах, шийдвэр гаргах нарийн төвөгтэй аргачлал тул амар ил тод болохгүй. Гэтэл хувьцаа эзэмшигчид бүх зүйлсийг ил тод, нээлттэй байлгахыг эрмэлздэг нь ТУЗ-ийн хувьд хүндрэл учруулж болзошгүй. Хувьцаа эзэмшигчид ТУЗ-ийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй байх тохиолдолд шинэ технологи нэвтэрснээр асуудлыг улам хурцатгах магадлалтай ба шинэ технологиос үүдэлтэйгээр ёс суртахууны асуудал, тэр дундаа программ хангамжийн олон шийдлүүдийн хэвшмэл байдлыг хэрхэн даван туулах талаар төлөвлөх, нухацтай хандах шаардлагатай.

Мэдээллийн хүртээмж:

Компанийн ТУЗ нь бизнесийн бүх үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг, хариуцлагатай хэдий ч тайлан мэдээ гаргуулах зэрэг хуучирсан аргаар хандсаар байвал мэдээллийн хомсдолд орж, ач холбогдол бүхий чухал шийдвэр гаргахад

хүндрэл учирна. Технологи хөгжиж, Байгаль орчин, нийгэм, засаглал /БОНЗ/-ын хүчин зүйлсийн ач холбогдол улам бүр нэмэгдэхийн хажуугаар кибер аюулгүй байдлын асуудал хурцаар хөндөгдөж байгаа өнөө үед ТУЗ тайлан, мэдээллийг цуглуулах, төвлөрүүлэн хянах үр дүнтэй систем байхгүй бол өрсөлдөх чадвараа алдах, цаашлаад зохицуулалтын дүрэм, журмыг зөрчих магадлалтай.

Ур чадвар:

Ойрын жилүүдэд ажлын байрны орчин өөрчлөгдөн шинэчлэгдэж байна. 2023 онд шинээр ажилтан нэмж авахаа зогсоосон эсвэл ажлын байрны цомхотголоос улбаалан туршлагатай, ур чадвартай ажилтны хомсдолд орох магадлалтай бөгөөд өөрөөр хэлбэл ТУЗ-ийн өмнө компанийн залгамж, халааны бодлогын хэрэгжилтэд бэрхшээл үүсэх эрсдэл байна.

Компани амжилтад хүрэхийн тулд чадварлаг, залуу хүний нөөц шаардлагатай бөгөөд ажилтны хууль эрх зүй, кибер аюулгүй байдал, санхүүгийн болон өгөгдлийн анализ зэрэг олон талт ур чадварыг хөгжүүлэх нь зүйтэй.

ТУЗ-ийн үнэлгээ:

ТУЗ-ийн жилийн үйл ажиллагааны үр дүн нь хөрөнгө оруулагчид болон оролцогч талуудын анхаарлын төвд байсан хэвээр байгаа ба тэд ТУЗ болон компанийн гүйцэтгэх удирдлагыг хууль журмаар хүлээсэн үүргээ ягштал биелүүлэхээс гадна шударга ажиллахыг хүсдэг. Ингэснээр санхүүгийн орлогыг нэмэгдүүлж, компанийн үйл ажиллагааны өргөн хүрээнд сайнаар нөлөөлнө гэж үздэг байна.

Иймд ТУЗ-ийн бүрэлдэхүүний олон талт байдал, хариуцлага, эрсдэлийн удирдлага зэрэг хүрээг хамарсан цогц үнэлгээг жил бүр тогтмол хийж, ил тод байлгах нь чухал.

Үргэлжлэл бий...


Эх сурвалж: www.deloitte.com

ФИНТЕК БА РЕГТЕК

ОЛОН УЛСЫН ФИНТЕКИЙН САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН


2023 он бол дэлхийн финтекийн зах зээлийн хувьд хүнд жил байсан бөгөөд финтекийн нийт хөрөнгө оруулалт 113.7 тэрбум ам.долларт, финтекийн хэлцлийн тоо 4,547-т хүрсэн нь 2017 оноос хойших хамгийн бага өсөлтийг үзүүлсэн жил байлаа. Төв банкнуудын зүгээс барьж буй бодлогын хүүгийн түвшин, инфляцын нөлөө, Украин болон Ойрхи Дорнод дахь зөрчилдөөн зэрэг олон сорилтоос үүдэлтэйгээр финтекийн зах зээлийн хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтдаа улам болгоомжтой хандах нөхцөл бий болгож байна.

Зураг. Дэлхийн финтекийн зах зээлийн нийт санхүүжилт (VC, PE болон M&A) 2020–2023




Финтекийн хөрөнгө оруулалтын бууралт нь бүх бүс нутгуудад тохиолдсон Ази Номхон далайн бүс (ASPAC)-д 2022 онд хөрөнгө оруулалт 51.3 тэрбум ам.доллар байсан бол 2023 онд ердөө 10.8 тэрбум ам.доллар болон буурч хамгийн их уналтад байна. Мөн Европ, Ойрхи Дорнод, Африк (EMEA) 2022 онд 49.6 тэрбум ам.доллар байсан бол 2023 онд 24.5 тэрбум ам.доллар болж, АНУ 2022 онд 95.4 тэрбум ам.доллар байсан нь 2023 онд 78.3 тэрбум ам.доллар болж тус тус буурсан.

Зураг. АНУ-ын финтекийн зах зээлийн нийт санхүүжилт (VC, PE болон M&A) 2020–2023




Зураг. Төлбөр төлөлтийн нийт санхүүжилт (VC, PE болон M&A) 2020–2023



Финтекийн дэд салбарууд дундаас төлбөр төлөлт нь 2022–2023 оны хооронд 57.9 тэрбум ам.доллаароос 20.7 тэрбум ам.доллар болж буурсан хэдий ч финтекийн санхүүжилтийн хамгийн их хувийг эзэлсээр байна.

Зураг. Иншуртекийн нийт санхүүжилт (VC, PE болон M&A) 2020–2023

Финтекийн томоохон дэд салбаруудаас проптек** болон иншуртекийн хөрөнгө оруулалт өмнөх жилийнхээс өссөн байна. Жилд проптекийн хөрөнгө оруулалт 4.1 тэрбум ам.доллаароос 13.4 тэрбум ам.доллар болж, иншуртекийн хөрөнгө оруулалт 5.9 тэрбум ам.доллаароос 8.1 тэрбум ам.доллар болж өссөн бөгөөд 2023 онд санхүүжилт буурсан ч хиймэл оюун ухааны татсан финтекийн хөрөнгө оруулалт 12.1 тэрбум ам.доллар байгаа нь технологийн салбарын хөгжлийн нөлөө хэвээр байгаа.



Эх сурвалж: Pulse of Fintech H2'23, Global Analysis of funding in Fintech, KPMG International

Тайлбар: Проптек** PropTech=Property+Technology Үл хөдлөх хөрөнгийн (ҮХХ) технологид суурилсан инновацуудыг хамруулж ойлгоход ашигладаг нэр томъёо.

СУДЛААЧИЙН ИНДЭР

ИНСУРТЕКИЙН ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, газрын референт
Б.Тэргэл tergel@frc.mn

ХУРААНГУЙ

Хурдтай өөрчлөгдөж буй орчинд даатгалын салбар нь эрчим хүчний шилжилт, эргэлтийн эдийн засаг, нэмэгдэж буй хотжилт, дижиталчлал зэрэг урьд өмнө байгаагүй өөрчлөлтүүдийг даван туулах үетэй нүүр тулсан. Маш удаан хугацаанд эдгээр хэв маяг нь бидний хэрхэн ажиллаж, амьдрахад нөлөөлөх билээ. Ковид-19 цар тахал, инфляц, дайн, улс төрийн орчин зэрэг гаднын хүчин зүйлс зах зээлд ихээхэн нөлөөлсөн. Сүүлийн жилүүдэд даатгалын салбар нь их төвөгтэй, олон янз болсон. Даатгалын технологи (инсуртек) олон жилийн өмнөөс бий болсон ч сүүлийн жилүүдэд хэрэгцээ нь огцом өссөн. Өнөөгийн эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлаас үл хамааран 2020 оноос хойш инсуртек нь зах зээлийг өөдрөг үзлээр хөдөлгөж, гэрээний тоо, санхүүжилтийн хэмжээ мэдэгдэхүйц нэмэгдсэн байна. Сүүлийн хэдэн жилийн хугацаанд уламжлалт даатгалын компаниуд дижитал бизнесийн загварт шилжихийн чухлыг ойлгож эхэлж байна. Энэхүү судалгааны ажлыг инсуртекийн бүтээгдэхүүнүүд болон олон улсын сайн туршлагаууд болон Монгол Улсад нэвтрүүлэх боломжтой орчныг бүрдүүлэх зорилгоор хийж гүйцэтгэн холбогдох санал, дүгнэлтийг боловсрууллаа.

УДИРТГАЛ

Дэлхий даяар инсуртекийн байнга хувьсан өөрчлөгдөж буй орчинд Монгол Улс уламжлалт, технологийн шинэчлэлийн уулзвар дээр зогсож байна. Даатгалын уламжлалт үйл явцыг оновчтой болгох, сайжруулахад чиглэсэн технологийн дэвшлийн давлагааг Монгол Улсад инсуртек авчрах юм. Эдгээр шинэлэг зүйл нь Монголын хүн амын хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээг хангахаас гадна даатгалын үйлчилгээний үр ашиг, хүртээмжийг хангахад хувь нэмэр оруулна.

Дижитал платформ, хиймэл оюун ухаан, өгөгдлийн шинжилгээний нэгдмэл байдал нь даатгалын бүтээгдэхүүнийг хэрхэн бүтээх, түгээх, удирдахад хувьсгал хийж байна. Хялбаршуулсан андеррайтерийн үйл явцаас эхлээд хувь хүнд тохирсон даатгалын гэрээг санал болгох гэх мэт инсуртек нь






илүү харилцагч төвтэй, мэдрэмжтэй даатгалын салбарыг бий болгох замыг нээж байна. Хиймэл оюун ухаан, блокчэйн, мэдээллийн аналитикийг нэгтгэснээр уламжлалт даатгалын тогтолцоог шинэчилж, илүү боловсронгуй болгож зах зээлд ажиглагдаж буй хувьслын тодорхой үе шатуудыг ахиулах юм. Энэхүү судалгааны хүрээнд инсуртекийн ач холбогдлыг судлан сүүлийн үед ашиглаж байгаа инсуртекийн хамгийн эрэлттэй бүтээгдэхүүний талаар болон түүний төрөл, онцлог, зохицуулалт ба улс орнуудын сайн туршлагыг судлан манай улсын даатгалын салбар дахь инсуртекийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар саналаа оруулахад чиглэсэн.

ИНСУРТЕК






Даатгалын компаниуд бизнесийн үйл явцыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор хиймэл оюун ухаан (AI), зүйлсийн интернэт (IoT) болон блокчэйн зэрэг шинээр гарч ирж буй технологиудыг ашиглаж байгаа нь инсуртек юм. Инсуртек стартапууд эдгээр шинэ технологиудыг хамгийн түрүүнд хөшүүрэг болгож байсан бол үндэсний томоохон даатгалын компаниуд өдгөө бизнесийнхээ олон салбарт инсуртекийг ашиглаж байна.

Инсуртек нь хэрэглэгчдийн хэрэгцээний өөрчлөлт, технологийн шинэ чадавхын өсөлт гэсэн хоёр хүчний огтлолцол дээр бий болсон.

ХЭРЭГЛЭГЧИЙН ХЭРЭГЦЭЭ, ХҮЛЭЭЛТ

-  Үнийн эмзэг байдал
-  Түрээслэх, өмчлөх
(ялангуяа залуу хэрэглэгчдийн дунд)
-  Хотод бага жолоодох
(Уян хатан байдал)
-  Хэрэглэгч төвтэй туршлага
(Тав тухтай байдал, ил тод байдал)
-  Илүү их технологийн мэдлэгтэй хэрэглэгчид (эрэлттэй эдийн засаг)

ШИНЭ ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН ЧАДАВХ

-  Платформд суурилсан аргууд
(Дижитал)
-  Хувийн тохиргоо болон захиалгат үйлчилгээ
-  Хүсэлтийн дагуу үйлчилгээ
-  Урьдчилан таамаглах аналитик
(нөхөн төлбөрийн мэдүүлэг, ирээдүйн алдагдал, шимтгэл)
-  AI-д суурилсан хэрэгсэл ба автоматжуулалт (нөхөн төлбөрийн удирдлага)

Инсуртекийн хувьсал: 2010–аад оны дундуур санхүүгийн үйлчилгээний бусад салбараас ялгаатай нь даатгалын салбар нь шинэ технологи, бизнесийн загвараар үндсэндээ тасалдаагүй. Гэсэн хэдий ч олон их наяд долларын дэлхийн аж үйлдвэрийн бүхий л салбарт чиглэсэн инсуртек стартапууд олширч, энэ салбар маш чухал эргэлтийн цэгт тулгарсан. Уламжлалт ёсоор маш нарийн, өндөр зохицуулалтын үйл явцтай байсан салбар хурдацтай ганхав. Ковид–19 цар тахал 2019 оны сүүлээр дэгдсэний дараа томоохон гарааны өсөлт дээд цэгтээ хүрч, өсөлтийн хурд бага зэрэг буурсан. Үүнд 2020 оны эхээр дэлхийн хэмжээний томоохон хорио/тусгаарлалтын үеэр хөрөнгийн зах зээл дэх тодорхой бус байдал, аж үйлдвэрийн эхлэлийн үе шатнаас хэтэрсэн төлөвшил голлон нөлөөлсөн. Өнөөгийн байдлаар Ковид–19–ийн урьд өмнө хэзээ ч байгаагүй нөлөөллөөс болж цочирдсон үйлчлүүлэгчид даатгалыг нэн тэргүүнд тавьж байгаа ч уламжлалт даатгалын компанид хандах хандлага өөрчлөгдсөн. Цар тахлын дараах даатгуулагчид ерөнхийдөө дижитал туршлагыг эрэлхийлж байгаа бөгөөд энэ нь инсуртек салбарт цөөн тооны тогтсон тоглогчдын өсөлтийг бий болгож 2020 онд олон нийтэд бүртгэлтэй инсуртекийн зах зээлийн үнэлгээ 22.0 тэрбум доллароос давж байна.

ИНСУРТЕКИЙН ХӨГЖИЛ

Хэрэглэгчдийн үйлчлүүлэгчдэд саадгүй хаана ч, хэзээ ч үйлчлүүлэх боломжтой үйлчилгээний талаарх хүлээлт нь инсуртек салбарын хувьслыг голчлон удирддаг. Даатгагчид ашигт ажиллагааг нэмэгдүүлж, үйл ажиллагааны зардлыг бууруулахын зэрэгцээ үйлчлүүлэгчдийнхээ сэтгэл ханамжийг хангах шаардлагатай байдаг. Эдгээр хүлээлт, хэрэгцээ нь их хэмжээний өгөгдлийн багц болон тэдгээрийг технологиор удирдах, ашиглах хэрэгслүүдийн хүртээмж нэмэгдэж байгаатай нийлж байна. Өөрсдийгөө инсуртек гэж нэрлэсэн компаниудын тоо үүнээс хойш өргөжин тэлж, харилцан уялдаатай үйлчилгээ, бүтээгдэхүүн санал болгох өргөн уудам, хөгжиж буй системийг багтаасан.

Зураг. Инсуртекийн хөгжил



Хүснэгт. Олон улсын инсуртекийн хөгжил

Үнийн харьцуулалт ба зуучлагчид	Удирдах ерөнхий агент, тодорхой салбарын сегментэд анхаарлаа төвлөрүүлдэг компаниуд болон процесс	Дэд бүтэц	Экосистем
2010–2012	2013–2016	2017–2018	2019–одоо
Цахим даатгалын хураамжийн тооцоо, цахимаар оруулсан мэдээлэл	Цахим түгээлт	IoT интеграцчилал	Даатгалд хамрагдах хэмжээг нэмэгдүүлэх
Хялбар нэвтрэлт	Олон төрлийн бүтээгдэхүүн	Технологийн багц	White labelling /нэг компанийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг өөр компаниар заруулах/
Сайн маркетинг	Автоматжуулсан процесс	Бодлогын нөхөн төлбөрийн удирдлага	IaaS / Үүлэн тооцооллын үйлчилгээний нэг төрөл /
			Угсармал даатгал

Эх сурвалж: drakestar.com

ИНСУРТЕК БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

Дижитал технологи нь хэрэглэгчдийн хүлээлтийг өөрчилж, салбарын хил хязгаарыг дахин тодорхойлсоор байна. Дэлхийн мегатренд "угсармал экосистем" –ийн зэрэгцээ инсуртекийн ирээдүйг тодорхойлох бусад томоохон чиг хандлага бий. Шинээр гарч ирж буй инсуртек бүтээгдэхүүнүүд болон тэдгээрийг хэрхэн зохицуулдаг тухай зарим жишээг дурдвал:

Параметрик даатгал /Parametric insurance/

Параметрик даатгал нь хувьсан өөрчлөгдөж буй индексэд суурилсан даатгалын бүтээгдэхүүний шинэ ангилал юм. Индекс дээр суурилсан даатгалын бодлого нь хур тунадасны түвшин эсвэл салхины хурд зэрэг урьдчилан тогтоосон индекс дээр үндэслэн нөхөн төлбөрийг төлдөг. Параметрик даатгал нь тодорхой хэмжүүрийн хүрээнд явагддаг. Уламжлалт даатгалаас ялгаатай нь параметрик даатгал нь даатгуулагчийн бодит хохирлыг нөхөн төлдөггүй. Бодит алдагдал нь параметрик даатгалд бараг хамааралгүй юм. Үүний оронд параметрик даатгал нь даатгуулагчийг урьдчилан тодорхойлсон үйл явдлын магадлалаас хамгаалдаг. Жишээлбэл, хар салхины үед уламжлалт даатгал нь даатгуулагчийн нөхөн төлбөр болон бодит хохирлын үнийг төлдөг бол параметрик даатгалын бодлого нь бодит хохирлоос үл хамааран салхи тодорхой хурдтай болсон эсэхээс хамаарч нөхөн төлбөрийг төлдөг. Параметрик даатгалын бүтээгдэхүүнүүд нь олон төрлийн эрсдэлд зориулагдсан байдаг бөгөөд даатгуулагчдын хэрэгцээг хангахын тулд шинэ бүтээгдэхүүнүүд байнга боловсруулагддаг боловч ихэвчлэн параметрик даатгалд хамрагдах эрсдэлүүд нь түүхэндээ даатгахад хэцүү байсан эрсдэлүүд байдаг – маш их хохирол учруулдаг ховор тохиолдлууд. Параметрик даатгалын компаниуд одоогоор уламжлалт даатгалын компаниудтай ижил зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Уламжлалт даатгалын төлөвлөгөө нь ихэвчлэн жил бүр байдаг бол параметрик даатгалын бүтээгдэхүүн нь ихэвчлэн таван жил хүртэлх олон жилийн төлөвлөгөө байдаг. Өөрөөр хэлбэл, зарим параметрик төлөвлөгөө нь улирлын шинж чанартай бөгөөд жишээлбэл, хар салхины улирал эсвэл ган гачгийн үед л эрсдэлийг даатгах зорилгоор ажилладаг. Ихэнх параметрик даатгалын бүтээгдэхүүнийг бизнес эрхэлдэг үйлчлүүлэгчид эсвэл Засгийн газрын нэгжүүдэд зориулж бичсэн бөгөөд захиалгат гэрээтэй байдаг. Стандарт бодлогыг зарахаас илүүтэйгээр ихэнх даатгагчид даатгуулагчтай шууд хамтран ажиллаж, даатгуулагчийн эрсдэлд тохирсон параметрик даатгалын төлөвлөгөөг боловсруулдаг. Эдгээр нь ихэвчлэн олон сая доллар төлдөг өндөр үнэ цэнтэй, өндөр өртөгтэй төлөвлөгөө юм. Параметрик даатгал нь даатгуулагчийн цорын ганц даатгалын бодлого биш бөгөөд үүний оронд энэ нь урьдчилан таамаглаж болохуйц, боломжийн алдагдлын дараа хөрвөх чадварыг нэмэгдүүлэх уламжлалт даатгалын нэмэлт үүрэг гүйцэтгэдэг.

Угсармал даатгал /embedded insurance/

Угсармал даатгал нь хэрэглэгчдэдээ хамгийн их хэрэгцээтэй үе болон газарт тохирсон, ердийн даатгалыг өргөн цар хүрээтэй борлуулах боломжтой бүтээгдэхүүн юм. Даатгалын функцийг технологи болгон хувиргаснаар угсармал даатгал нь аливаа гуравдагч этгээдийн үйлчилгээ үзүүлэгчид шинэлэг даатгалын бүтээгдэхүүнийг үйлчлүүлэгчдийнхээ худалдан авалтад саадгүй, хурдан бөгөөд хямд үнээр нэгтгэх боломжийг олгодог. Эцсийн үр өгөөж нь үйлчлүүлэгчдэд илүү үнэ цэнтэй санал болж, улмаар брэндийн давуу талыг бий болгож, улмаар үйлчлүүлэгчийн үнэнч байдлыг бий болгодог. Угсармал даатгалын үндсэн зорилго нь даатгалын бүтээгдэхүүнийг өдөр тутмын амьдралын олон талбарт саадгүй оруулж, хамгийн хэрэгцээтэй, хамааралтай үед хамгаалалтыг санал болгох явдал юм. Эдгээр салбаруудтай ихэвчлэн хамтардаг салбарууд: аялал жуулчлал, тоглолт, мотор болон шинэ хөдөлгөөн, цахим худалдаа, санхүүгийн үйлчилгээ гэх мэт.


Угсармал даатгалын гарал үүсэл

Угсармал даатгалыг өөр бүтээгдэхүүн, үйлчилгээний арилжааны гүйлгээний хүрээнд худалдан авч болох аливаа даатгалын бүтээгдэхүүн гэж тодорхойлдог. Анхны жишээ бол нислэгийн өмнө нисэх онгоцны буудал дээр амьдралын даатгал худалдаж авах боломж юм. Бусад анхны жишээнүүдэд автомашины даатгал зардаг автомашины худалдагчид, түрээсийн машинтай хамт автомашины түрээсийн даатгал худалдаж авах, цахилгаан хэрэгсэл худалдан авахад санал болгож буй баталгаат хугацаа зэрэг орно.

Түүнээс хойш угсармал даатгал хөгжиж ирсэн. Энэхүү хувьсалд технологи ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. Хэрэглэгчдэд бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгодог компаниуд өнөө үед дижитал борлуулалтын сувгийг ихэвчлэн ашигладаг. Ийм учраас угсармал даатгалыг цахим худалдааны платформуудаар дамжуулан онлайн борлуулалтын урсгалд оруулах, аппликэйшн эсвэл бие даасан цахим хуудаснуудаар дамжуулан түгээж байна.

Телематик буюу хэрэглээнд суурилсан даатгал

Зураг. Телематик даатгал



Телематик даатгалыг хэрэглээнд суурилсан даатгал, жолоодсоныхоо хэрээр төлөх даатгал эсвэл миль тутамд төлөх даатгал гэж нэрлэдэг. Телематик даатгал нь ногоон даатгалын бүтээгдэхүүнүүдийн 1 бөгөөд хяналтын технологийг ашиглан автомашины даатгалын тарифыг тохируулахад ашигладаг. Үүнийг хэрэглээнд суурилсан даатгал (UBI) гэж бас нэрлэдэг. Энэ нь хоёр хэлбэрээр ирдэг. Миль/км дээр суурилсан даатгал нь таны хэр их машин жолоодож байгаагаас хамаарч хувь хэмжээг тогтоодог. Зан төлөвт суурилсан даатгал нь аюулгүй жолоодлогын үндсэн дээр хөнгөлөлт үзүүлдэг. Даатгалын компаниуд таны машинд төхөөрөмж эсвэл мобайл программ суулгаж хянадаг. Үүсгэсэн өгөгдөл нь таны машины даатгалын хэмжээг тогтооход тусална.

Open insurance буюу даатгалын хяналтын самбарын үйлчилгээ

Нээлттэй даатгал гэдэг нь үндсэндээ шинэ үйлчилгээ, программууд болон шинэлэг/сөрөг бизнесийн загваруудыг бий болгохын тулд түншүүд, нийгэмлэгүүд

болон гарааны компаниуд үйлчилгээ, мэдээлэл өгөхийг хэлнэ. Нөгөөтээгүүр, энэ нь даатгалын зах зээлийн янз бүрийн тоглогчдын хооронд, түүний дотор арын албанд болон хэрэглэгчдэд шууд "харагдахгүй" байдлаар API-ээр дамжуулан илүү өргөн мэдээлэл солилцохыг тайлбарлахад хэрэглэгддэг. Үүнд хувийн болон хувийн бус мэдээллийг хоёуланг нь багтааж болно. Даатгалын олон бүтээгдэхүүний нарийн төвөгтэй байдал нь хэрэглэгчдэд даатгалын ерөнхий нөхцөл байдлыг ойлгоход хэцүү болгодог. Түгээмэл асуултууд:

Тэд ямар даатгалын гэрээтэй вэ?

Тэдний одоо байгаа даатгалын гэрээнд юу хамрагдах вэ?

Ямар эрсдэл нэгээс олон удаа хамрагдах вэ?

Юу хамрагдахгүй вэ?

Ямар нэмэлт бүтээгдэхүүн шаардлагатай байж болох вэ?

Ямар бүтээгдэхүүн тэдний эрэлт хэрэгцээнд нийцэхгүй байж болох вэ?

Даатгалын хяналтын самбар нь бүх даатгалын компани/зуучлагчдын мэдээллийг нэгтгэж холбоо барих төв цэгийн үүрэг гүйцэтгэдэг нэг дор одоо байгаа даатгалын гэрээ болон холбогдох мэдээллийг хэрэглэгч бүрд цуглуулж харуулах боломжтой. Нэмж дурдахад, энэ нь бусад даатгалын компаниуд/зуучлагчдад өөрсдийн бүтээгдэхүүний мэдээллийг оруулах боломжийг олгож, хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэгчдийн хоорондын хамрах хүрээ, үнийг харьцуулах боломжийг олгоно. Энэ нь илүү олон тооны хэрэглэгчдэд хамааралтай бүх мэдээллийг утга учиртай, хэрэглэгчдэд чиглэсэн байдлаар авах өөр хувилбар гэж үзэж болно.

ДУГНЭЛТ, САНАЛ

Дэлхий даяар инсуртек нь даатгалын салбарт эерэг өөрчлөлтүүдийг авчирсан. Хиймэл оюун ухаан, их өгөгдлийн шинжилгээ, блокчэйн зэрэг дэвшилтэт технологийг ашиглан инсуртек нь үйл явцыг оновчтой болгож, үр ашгийг дээшлүүлж, хэрэглэгчийн туршлагыг мэдэгдэхүйц сайжруулсан. Телематик болон хэрэглээний төхөөрөмж зэрэг шинэлэг шийдлүүдийн тусламжтайгаар инсуртек нь эрсдэлийн хувийн үнэлгээг хийж, даатгалын компаниудад илүү тохирсон, хямд даатгалын бүтээгдэхүүнийг санал болгох боломжийг олгосон. Нэмж дурдахад ухаалаг гэрээ, нээлттэй даатгалын хяналтын самбарын үйлчилгээ нь технологи ашиглан ил тод байдлыг нэмэгдүүлж, залилан мэхлэх явдлыг бууруулж, илүү найдвартай даатгалын орчныг бүрдүүлсэн. Ерөнхийдөө инсуртек нь даатгалын уламжлалт арга барилыг шинэчлээд зогсохгүй илүү динамик, мэдрэмжтэй, үйлчлүүлэгч төвтэй даатгалын орчныг бий болгож байна.

Монгол Улсын даатгалын салбарын хөгжил аажмаар хөгжиж байгаа ч даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний цахимжилт хараахан нэвтрээгүй байна. Инсуртекийг түгээж хэрэгжүүлснээр бүтээгдэхүүний төрөл ихсэж, илүү хүртээмжтэй мөн өгөөжтэй болох боломжтой юм.

Дээр дурдсан бүтээгдэхүүнүүд Монгол Улсад:

- ◆ Параметрик даатгал – Монгол Улсад ган гачиг, зуд, үер гэх мэт олон төрлийн байгалийн гамшиг их тохиодог бөгөөд индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнүүдээс Монголд үерийн индексжүүлсэн болон малын индексжүүлсэн даатгал байна. Эдгээр даатгал нь тохирсон нөхөн төлбөрөө жилийн сүүлд олгодог бол параметрик даатгал нь яаралтай эрсдэлийн нөхөх зорилгоор тохирсон нөхцөл нь бүрдсэн үед шууд олгодог даатгал давуу талтай юм. Мөн даатгуулагч даатгуулсан эд зүйлээ эрсдэлд орох үед яаралтай зургаар баталгаажуулж болдог ороо онцлогтой юм.
- ◆ Угсармал даатгал нь олон улсын хувьд өргөн ашиглагдаж байгаа бөгөөд даатгалын төрлийг нэмж, хэрэглэгчдэд хялбар байдлаар өөр бүтээгдэхүүн үйлчилгээний багцад дагалдаж ирдгээрээ онцлог юм. Манай улсад зохицуулалт байхгүй бөгөөд хуулинд нэмэлт өөрчлөлт оруулбал бүтээгдэхүүний төрөл нэмэгдэж, хэрэглэгчдийн тоо ихсэх боломжтой даатгалын төрөл юм.
- ◆ Телематик даатгал – 2023 оны байдлаар Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөнд 570 орчим мянган машин оролцож байгаа нь улсын хэмжээнд бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн 80 орчим нь замын хөдөлгөөнд оролцож байна. Үүнээс үзэхэд түгжрэл дээд цэгтээ хүрч байна. Мөн 2022 онд Монгол Улсад нийт 24,121 зам тээврийн осол үүссэн бөгөөд 96.5 хувь буюу 23,277 нь жолоочийн буруугаас шалтгаалсан осол гарсан байна. Телематик даатгал нь жолооч машин зам дээр оролцсон хэмжээгээрээ хураамж төлдгөөрөө давуу талтай бөгөөд дүрмээрээ сайн жолоодсон жолоочоос хураамж бага авдаг ба энэхүү бүтээгдэхүүн нь ослын тоог бууруулж, эрсдэл үүссэн тохиолдолд түргэн үнэлдгээрээ онцлогтой тул манай улсад нэн чухал бүтээгдэхүүний нэг болоод байна.
- ◆ Нээлттэй даатгал нь манай улсад бий болсноор хэрэглэгчид даатгалын талаар илүү ойлголттой болж, өөрийн шаардлагад таарсан бүтээгдэхүүнээ харьцуулан сонгох боломжтой юм. Харин даатгагчдын хувьд компанийн өрсөлдөх чадвар нь дээшилж, бүтээгдэхүүнүүдээ хүмүүст хүртээмжтэй борлуулах боломжтой. Мөн даатгалын салбар нь нэгдсэн өгөгдөлтэй болох боломж үүсэх юм.

Монгол Улсад инсуртекийн бүтээгдэхүүнүүд сайн хөгжихгүй байгаа хамгийн том шалтгаануудын нэг:

- ◆ Иргэдийн инсуртекийн талаар мэдээлэл, ойлголт муу байна. Энэ нь инсуртекийн талаар сургалт, мэдээлэл түгээдэг газар байхгүйтэй холбоотой бөгөөд хүмүүсийн даатгалын мэдлэг муу байгаатай холбоотой юм.
- ◆ Даатгалын компаниудын цахим үйлчилгээ, бүтээгдэхүүн тааруу байна. Даатгалын компаниудын ажиллагсдын чадавхын асуудал болон хүний нөөцтэй шууд хамааралтай гэж үзэж байна.
- ◆ Даатгалын салбарын цахим үйлчилгээ, бүтээгдэхүүнийг дэмжих хууль дүрэм, журам хангалтгүй. Одоогоор Монгол Улсад зөвхөн “Даатгалын багц дүрэм” дээр цахим даатгалын бүтээгдэхүүн болон үйлчилгээний талаар дурдагддаг.

Монгол Улсад инсуртекийг хурдтай нэвтрүүлэхэд дараах зүйлс шаардлагатай байна:

- ◆ Дижитал платформ болон гар утасны аппликэйшн нэвтрүүлэлтийг сайжруулах нь даатгалын бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлж, хот, хөдөөгийн өргөн хүрээний хүн амд хүрч чадна. Одоогийн асуудлыг шийдэхийн тулд даатгалын компаниудын болон даатгуулагчдын сэтгэл ханамжийн судалгаа авах шаардлагатай байна. Энэхүү судалгаагаар хаана, юу болохгүй байгааг харан энэ асуудал дээр анхаарал хандуулах боломжтой.
- ◆ Хэрэглэгчийн эрх ашиг, мэдээллийн аюулгүй байдал, цахим гэмт хэргээс хамгаалахын тулд технологид суурилсан бүтээгдэхүүн,

үйлчилгээг зохицуулах хууль, эрх зүйн орчныг сайжруулж, нэмэлт оруулах шаардлагатай.

Техник, технологийг шинэчилж, өргөжүүлэх хэрэгцээ үүссэн. Блокчэйн зэрэг шинэлэг технологийг нэвтрүүлэх нь даатгалын гүйлгээний ил тод байдал, итгэлцлийг нэмэгдүүлж, залилан мэхлэлтийг бууруулахад тусалдаг.

Эцэст нь Монгол дахь инсуртек нь даатгалыг илүү хүртээмжтэй, үр ашигтай, хүн амын тодорхой хэрэгцээнд нийцүүлэхийн зэрэгцээ улс орны санхүүгийн үйлчилгээний салбарын хөгжилд хувь нэмэр оруулах боломжтой юм.

ЭХ СУРВАЛЖ

1. Carlos Ordycez, 2022, Regulation and Innovation in the Era of Open Insurance, Эх үүсвэр: <https://insurance.nttdata.com/post/regulation-and-innovation-in-the-era-of-open-insurance/>
2. Consumer Federation of America, 2021, Auto Insurance Telematics Programs Require New Consumer and Privacy Protection Standards to Achieve Safety and Pricing Promises, Эх үүсвэр: https://consumerfed.org/press_release/new-white-paper-released-auto-insurance-telematics-programs-require-new-consumer-and-privacy-protection-standards-to-achieve-safety-and-pricing-promises/
3. Daniel Robinson, Rashawn Mitchner, 2023, Telematics Insurance, Эх үүсвэр: <https://www.marketwatch.com/guides/insurance-services/telematics-insurance/>
4. Drake Star, 2022, Insurtech Industry Report, Эх үүсвэр: <https://www.drakestar.com/hubfs/Research/INSURTECH/Global%20InsurTech%20Industry%20Report%202022.pdf>
5. Fredrik Andrén, 2022, How can insurers prepare for the era of open insurance?, Эх үүсвэр: https://www.ey.com/en_se/financial-services/how-can-insurers-prepare-for-the-era-of-open-insurance
6. InsureTheBox, 2023, What is black box car insurance?, Эх үүсвэр: <https://www.insurethebox.com/telematics>
7. Lindsay Bishop, 2023, Telematics Insurance: Is It Right for You?, Эх үүсвэр: <https://www.valuepenguin.com/car-insurance/telematics>
8. National Association of Insurance Commissioners, 2023, PARAMETRIC DISASTER INSURANCE, Эх үүсвэр: <https://content.naic.org/cipr-topics/parametric-disaster-insurance>
9. Publications Office of the European Union, 2021, OPEN INSURANCE:ACCESSING AND SHARING INSURANCE-RELATED DATA DISCUSSION PAPER, Эх үүсвэр: [open-insurance-discussion-paper-28-01-2021.pdf](https://publications.ec.europa.eu/publication-detail/-/publication/01111111-1111-1111-1111-111111111111) (europa.eu)
10. RINTECH, 2023, A Comprehensive Guide to Embedded Insurance, Эх үүсвэр: <https://www.rinf.tech/a-comprehensive-guide-to-embedded-insurance/>
11. Simon Torrance, Founder, Embedded Finance & Super App Strategies and Chris McMahon, Senior Marketing Manager, 2022, Embedded insurance: A new route to growth and value, EIS, United States
12. Swiss Re Corporate Solutions, 2023, Comprehensive Guide to Parametric Insurance, Эх үүсвэр: <https://corporatesolutions.swissre.com/dam/jcr:0cd24f12-ebfb-425a-ab42-0187c241bf4a/2023-01-course-guide-of-parametric-insurance.pdf>
13. The European Insurance and Occupational Pensions Authority, 2023, DISCUSSION PAPER on Open Insurance: an exploratory use case in the insurance sector



ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

ДЕРИВАТИВ БУЮУ ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ гэж өөрийн үнэ цэн нь суурь хэрэгслийн үнэ цэнээр тогтоогддог санхүүгийн хэрэгсэл юм.

ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН ДАВУУ ТАЛ



Ханшийн эрсдэлээс хамгаална



Гүйлгээний зардал бага



Эрсдэлээ удирдах боломжтой



Хөшүүрэг болгон ашиглах боломжтой



Хэлбэлзэл багатай харьцангуй тогтвортой



Таамаглалд суурилдаг

СУЛ ТАЛ



Хөрвөх чадвар бага



Эрсдэл өндөр



Хугацаа дуусах хүртэл цуцлах боломжгүй



Үнэлэхэд хэцүү

ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ НЬ ИХЭВЧЛЭН ГЭРЭЭ БАЙДАГ.



ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН ТӨРӨЛ

Своп гэрээ

Форвард
гэрээ

Фьючерс
гэрээ

Опцион
гэрээ



Своп гэрээ– талууд мөнгөн төлбөр, авлагыг ирээдүйд тогтоосон цаг хугацаанд солилцохоор тохиролцсон гэрээ юм



Форвард гэрээ– арилжаанд оролцогч талууд урьдчилж тохирсон үнээр гэрээнд заасан хөрөнгийг ирээдүйд худалдах, худалдан авахаар тохиролцох ба арилжаа нь ихэвчлэн биржийн бус зах зээл дээр хийгддэг.



Фьючерс гэрээ– зохион байгуулалттай биржийн зах зээлээр дамжуулан арилжаанд оролцогч 2 тал урьдчилж тохирсон үнээр гэрээнд заасан хөрөнгийг ирээдүйд худалдах, худалдан авах нөхцөлтэй.



Опцион гэрээ– талууд гэрээнд заасан хөрөнгийг тохиролцсон үнээр гэрээнд заасан хугацаанд худалдах, худалдан авахаар гэрээнд заасан ч гэрээний заасан хугацаа болохоос өмнө гэрээнээс татгалзах боломжтой.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО НЬ:



Үнэт цаасны үнэ



Арилжааны индекс



Гадаад валют



Уул уурхайн бүтээгдэхүүн



Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдэд



СУУРИЛСАН ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛТЭЙ ХОЛБОГДОХ
ХАРИЛЦААГ ХОЛБОГДОХ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИЦУУЛЖ БАЙНА.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ЯПОНЫ 02 ДУГААР САРЫН ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА СҮҮЛИЙН ГУРВАН ЖИЛД БАЙГААГҮЙ ХУРДАЦТАЙ БУУРЧЭЭ.



Японы Jibun Bank-ын мэдээлснээр үйлдвэрлэлийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 01 дүгээр сард 48.0 байсан бол хоёрдугаар сард 47.2 болж буурчээ. Энэ нь 2020 оны 8 дугаар сараас хойших ес дэх удаагийн бууралт бөгөөд хамгийн хурдан бууралт байлаа.

PMI-ийн үндсэн хоёр дэд индекс болох үйлдвэрлэл болон шинэ захиалга сүүлийн жилд хурдацтай буурахад судалгаанд оролцогчид дотоод болон гадаад дахь борлуулалтын эрэлт сул, машин механизм нийлүүлэлт зогссоны улмаас үйлдвэрлэл саатсан зэрэг хүчин зүйлсийг дурджээ.

Эх сурвалж: www.Cnbc.com

ХЯТАДЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ГЭРЭЭ ТАВ ДАХЬ САРДАА ДАРААЛАН ХИЙГДЭЖ БАЙГААГ АЛБАН ЁСНЫ ТОО БАРИМТ ХАРУУЛЖ БАЙНА.

БНХАУ-ын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа 2024 оны 02 дугаар сард тав дахь сардаа дараалан буурсныг албан ёсны тоо баримт харуулж байгаа нь үйлдвэрийн үйл ажиллагаа өргөжсөнийг илтгэсэн судалгаатай зөрчилдөж байна.

Хятадын Үндэсний Статистикийн Товчооны мэдээллээс харахад аж үйлдвэрийн салбарын PMI 01 дүгээр сард 49.2

байсан бол 02 дугаар сард 49.1 болж буурчээ. Энэ нь Ройтерс агентлагийн санал асуулгын тооцоотой таарж байна.




Харин Caixin/S&P Global үйлдвэрлэлийн PMI өмнөх сард 50.8-байснаа 02 дугаар сард 50.9 болж өссөн.

PMI-ийн 50-аас дээш үзүүлэлт нь тэлэлт, харин түүнээс доош байвал агшилтыг илтгэнэ.

“Компаниуд үйлдвэрлэл болон шинэ ажлын өсөлтийг тэмдэглэж, өсөлтийн хурд 01 дүгээр сараас бага зэрэг өссөн нь экспортын шинэ захиалгын өсөлтөд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн” гэж Caixin судалгаанд дурджээ..

Эх сурвалж: www.Cnbc.com

ЭНЭТХЭГИЙН 03 ДУГААР УЛИРЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ХҮЛЭЭЛТЭЭС ДАВСАН БАЙНА.



Энэтхэгийн эдийн засаг 2023 оны 4 дүгээр улиралд хүлээгдэж байснаас хамаагүй хурдацтай өссөн байна.

Тоо баримтаас харахад ДНБ төсөв 03 дугаар улиралд 8.4


хувиар өссөн нь хувийн хэрэглээний өсөлт, үйлдвэрлэл, барилгын салбарын идэвхтэй үйл ажиллагаатай холбоотойгоор Reuters-ийн санал асуулгын 6.6 хувийн өсөлтийн хүлээлтийг давсан байна.

4 дүгээр улирлын үзүүлэлт өмнөх 03 дугаар улирлаас 7.6 хувиар өссөн байна.

Энэтхэгийн засгийн газар 2023 оноос 2024 оны санхүүгийн жилийн ДНБ-ий өсөлтийн төлөвийг өмнө нь 7.3 хувь гэж таамаглаж байсныг 7.6 хувь болгон өсгөв.

Эх сурвалж: www.Cnbc.com

ПҮРЭВ ГАРАГТ NASDAQ БҮХ ЦАГ ҮЕИЙН ДЭЭД ЦЭГТЭЭ ХҮРЧ ХААГДЛАА.



АНУ-ын хөрөнгийн биржүүд пүрэв гарагийн арилжаагаа ногооноор дуусгаж, Nasdaq Composite хаалт дээд түвшинд хүрсэн байна.

Технологийн өндөр үнэлгээтэй Nasdaq нийлмэл хувьцааны ханш 0.9 хувиар өсөж, 16,091.92 нэгж болж бүх цаг үеийн хаалтын дээд цэгтээ хүрчээ.

Харин Dow Jones Industrial Average 47 нэгж орчим буюу 0.1 хувиар өсөж 38,996.39 нэгжид хүрсэн бол S&P 500 индекс 0.5 хувиар өсөж, 5,096.27-оор дээд амжилт тогтоосон байна.

Эх сурвалж: www.Cnbc.com

АНУ-ЫН КОРПОРАЦИЙН БОНДЫН БОРЛУУЛАЛТ 02 ДУГААР САРД 153 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРТ ХҮРЧ ДЭЭД АМЖИЛТ ТОГТООЖЭЭ.



Цэнхэр чиптэй компаниуд 02 дугаар сард АНУ-д 153 тэрбум ам.долларын бонд зарж, дээд амжилт тогтоогоод байгаа бөгөөд компаниуд зээл авах зардал буурсантай холбоотойгоор хөрөнгө оруулагчдын эрэлт хэрэгцээг хангахаар уралдаж байна.

Bloomberg News-ийн мэдээлснээр борлуулалт өнгөрсөн оны хоёрдугаар сард 150.9 тэрбум ам.доллар болж өмнөх дээд амжилтыг тэргүүлсэн. Бүтэн жилийн гүйлгээ 361 тэрбум ам.доллар давсан нь бас дээд амжилт юм. Борлуулалт сүүлийн хоёр жилийн хамгийн завгүй долоо хоногийн дараа гарч байгаа нь нэгдэх, худалдан авах үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор зарагдсан бондын үерээс үүдэлтэй юм. Мөн илүү олон бондын борлуулалт хийгдэх магадлалтай байна.


Эх сурвалж: Bloomberg.com

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2024 оны 02 дугаар сарын 29-ны өдөр

S&P 500 / ^GSPC/


5,069.76 -8.42 (-0.17%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 / ^N225/


39,064.85 -143.18 (-0.37%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 / ^FTSE/

7,624.98 -58.04 (-0.76%)



NASDAQ Composite (^IXIC)

15,947.74 -87.56 (-0.55%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia